Цахим худалдааны солилцоо нь Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны А/31 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/93 тоот тушаалын Наймдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу 2024 оны жилийн эцсийн тайланд шинээр авч буй мэдээлэл.

Энэ мэдээлэл нь Улс хоорондын солилцооны статистик тайлан мэдээнд тусгагдаагүй болно.

Гадаадаас Монгол улсруу чиглэсэн цахим худалдааны бараа илгээмжийг хүргэж гардуулсан байна.

2.3 Шуудангийн зах зээлийн зохицуулалтын үр нөлөөний талаар хийсэн судалгааны санал

Энэ хүрээнд “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх журам”-н “2.1.Зохицуулах хороо нь харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх зорилгоор захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, батлах, зохицуулалт хийхэд дараах зарчмыг баримтална:” заалтын дагуу шуудангийн тухай хууль болон холбогдох нөхцөл шаардлагын хүрээнд зах зээл дээр үүсээд байгаа нөхцөл байдалд үндэслэн дараах үнэлгээ, дүгнэлтийг хийж гүйцэтгэв. Үүнд:

2.1.1. Зохицуулалт нь үл ялгаварласан, нээлттэй ил тод, хэрэгжихүйц, түргэн шуурхай байх.

- Шуудангийн тухай хуулийн 10 Зүйл - Шуудангийн үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөл шаардагдахыг заасан;
- Үйлчилгээ эрхлэгч нь “101.4.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд Харилцаа холбооны тухай хуулийн 14.1-д зааснаас гадна шуудангийн үйлчилгээний зэрэглэлийг тусгана.” хүрээнд тус хороотой гэрээ байгуулан зөвшөөрөл авна;
- “14.1.Үйлчлэгч нь Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болно.” Нэмэлт санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалт;
- Дээрх судалгааны хүрээнд үндсэн 3 зөвшөөрөл байгаа мэт боловч зах зээл талаас нь авч үзвэл;
- Ялгаатай үйлчилгээний хүрээ, үйлчилгээ эрхлэх газар зүйн байршил хоорондоо ялгаатай мэт зөвшөөрлийн ойлголт болон хуучин байсан зөвшөөрлийн хүрээнд ангилагдсан хэвшмэл ойлголт буюу тус хороотой байгуулсан гэрээ болон зохицуулалтын үйлчилгээний хөлс зэрэг ялгавартай нөхцөл, нээлттэй бус асуудлууд байна;
- “ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА” (“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 53 дугаар тогтоол”-ын хавсралт) нь Шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч мөрдөж ажиллахаар батлагдсан. Тус нөхцөл шаардлагын хувьд зөвшөөрлийн төрөл ангилал, хамрах хүрээ, үйлчилгээ хоорондын ялгаа, заагыг тодорхойлж өгөөгүй мөн ямар шалгуураар хэрэгжилтийг хангуулах асуудал нь тодорхой бус байна;

2.1.2. Хяналт, хариуцлага нь ижил, тэгш үйлчилдэг байх;

- Зүйл 9 – Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавих эрхтэй.
- Нөхцөл шаардлагад үйлчилгээний тусгай зөвшөөрлийн агуулгаар ялгасан зохицуулалт байхгүй нийтлэг зохицуулалттай байх бөгөөд хэзээ хэрхэн яаж хяналт тавих талаар тодорхой зүйл заалт байхгүй нь хариуцлага, хяналтын асуудал яригдах боломжгүй гэж үзсэн. жишээ нь Улс хоорондын буухиа, улс хоорондын шуудан чиглэлтэй, шуудангийн сүлжээ, шуудангийн нэмэлт үйлчилгээ гэх мэт...
- 26.1.Шуудангийн сүлжээний ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологийн горимын хэрэгжилтэд хууль тогтоомжид заасны дагуу улсын байцаагч хяналт тавина.

2.1.3. Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын арга хэмжээ нь аливаа этгээдэд давуу байдал олгохгүй, үр ашигтай өрсөлдөөнийг дэмжих;

- Зүйл 10.4 – Тусгай зөвшөөрөл олгох эрхийг Зохицуулах хороонд олгосон боловч, хэн, ямар нөхцөлд авах боломжтойг ил тод тайлбарлаагүй. Зах зээлд шинэ оролцогчдод ямар ч давуу эсвэл сул нөхцөл үүсч болох талаар мөн нөхцөл шаардлага болон зөвшөөрлийн ангилал, зах зээлийн хамрах хүрээ нь ямар шалгуур, зохицуулалтаар тодорхойлогдож байгаа нь тодорхойгүй байна.
- Жишээ нь Шуудангийн сүлжээ(Улс хооронд) гэсэн ангилал болон БНХАУ аас Монгол Улс гэсэн чиглэл ээр авсан 2 зөвшөөрөл эзэмшигчид тавигдаж буй нийтлэг болон тусгайлсан зохицуулалтын агуулга, ялгаа нь тодорхойгүй, ойлгомжгүй.

2.1.4. Өрсөлдөөнд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах, үр ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцаа холбооны зах зээлд нэвтрэх саадыг бууруулах;

- Шуудангийн тухай хуулиар шуудангийн сүлжээ болон үйлчилгээг тодорхойлон ангилж зохицуулсан.
- 3.1.12."шуудангийн үндсэн сүлжээ" гэж төрийн өмчийн оролцоотой, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч шуудангийн сүлжээг;
- "3.1.2."шуудангийн сүлжээ" гэж шуудангийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын салбар, цэг болон тэдгээрийн хооронд шуудангийн илгээмж тээвэрлэх чиглэлийн нийлбэр цогцыг;" гэж заасан.
- 3.1.13."шуудангийн үйлчилгээ" гэж үйлчлүүлэгчээс шуудангийн илгээмж хүлээн авч шуудангийн сүлжээгээр дамжуулан хаягласан эзэнд нь хүргэх нэгдмэл үйл ажиллагааг;
- 5.1.7. шуудангийн сүлжээний ажиллагаа аюулгүй, тогтвортой байх;
- 5.1.8.шуудангийн салбарт дагаж мөрдүүлэх стандарт, дүрэм нь харилцан уялдсан, нэгдмэл байх.
- Шуудангийн сүлжээг төрийн оролцоотой, үүрэг хүлээсэн байх мөн тогтвортой байх талаар хуульчилсан тухайн сүлжээг үр ашигтай байлгах бодлого, зохицуулалтыг эрх бүхий байгууллагад хүлээлэгсэн.
- Шуудангийн зах зээлд сүүлийн үед нэвтрээд буй гараас гарт хүргэлтийн үйлчилгээ нь шуудангийн үйлчилгээг орлох үйлчилгээ эсэх талаар тодорхой судалгаа, материал байхгүй байна.
- Зах зээл дээр бий болсон хэрэгцээг хангах, үйлчилгээ эрхлэгчийн үр ашигтай байлгах, технологи, иновацийг нэвтрүүлэх, нэгдсэн зохицуулалтаар хангах хүрээнд нэгдсэн судалгаа дүгнэлтийг гаргах шаардлага үүссэн байна.

- Шуудангийн тухай хуулийн хүрээнд шуудангийн дэд бүтцийг сайжруулах бодлого баримтлах тухай заасан. Гэхдээ хувийн хөрөнгө оруулалтыг татах, нэвтрэх саад арилгах талаар харилцан үр ашигтай, хамтран ажиллах талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.
- Үр ашигтай, тогтвортой, зах зээл дэх сөрөг нөлөөллийг багсгах хүрээнд үйлчилгээ эрхлэгч болон зах зээл хооронд харилцан холболт, холболтын зохицуулалтыг үр дүнтэй авч хэрэгжүүлэх үүэг хариуцлагыг тодорхойлох шаардалгатай байна.

2.1.5. Инноваци, шинэ технологи нэвтрүүлэхийг дэмжих

- Шуудангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар төрөөс дэмжих бодлого гаргах эрх нь “7.1.2. шуудангийн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;” байгаа хэдий ч ямар бодлого чиглэл гарсан тэр нь зохицуулалтын хүрээнд хэрхэн хэрэгжиж байгаа талаар болон зохицуулалтад хэрхэн туссан, хэрэгжсэн талаар мэдээ, мэдээлэл судалгаа байхгүй байна.
- Мөн инноваци, шинэ технологийн талаар тусгайлан дэмжих механизм зохицуулалтын баримт бичигт тусгагдаагүй байна.

2.1.6. Хэрэглэгчийн сонголт, үнэ, чанарын боломжийг хангах

- Шуудангийн үйлчилгээний хувьд үнэ тарифын нарийвчилсан зохицуулалтыг хуулийн хүрээнд хангуулж байна. Гэсэн хэдий ч зах зээлийг хамарсан үнэ тариф болон үйлчилгээний чанар, хэрэглэгчийн бодит сонголтыг хангахуйц хяналтын мониторингийн нэгдсэн механизмгүй энэ талаар зохицуулалт нь тодорхой бус байна.

2.1.7. Судалгаанд үндэслэн зохицуулалт хийх

- Шуудангийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал нь шуудангийн салбарт баримтлах нэгдсэн бодлого болон төрийн оролцоо буюу үүрэг нь тодорхойгүй, баримтлах чиглэл нь хэт хуучин байсантай холбоотой гэж үзэж байна.
- Шуудангийн үйлчилгээг бизнес болон үүрэг гэсэн 2 агуулгаар салгаж авч үзэх ёстой гэж Дэлхийн шуудан холбооны байгууллага авч үздэг, түүнчлэн дараах агуулгаар зөвлөмж чиглүүлгийг гаргасан байна. Үүнд:
 - Үндсэн шуудангийн үйлчилгээнд
 - Иргэн бүрт хүрч ажиллах шуудангийн сүлжээ.
 - Хүртээмжтэй, хямд, тогтвортой шуудангийн үйлчилгээ.
 - Шуудангийн анхан шатны стандартыг тогтоож, чанар, хугацаа, хүртээмжийн шалгуур үзүүлэлтийг нийтлэг мөрдүүлэх.

- Зах зээлийн орчин буюу өрсөлдөөний нөхцөл байдал:
- Шударга өрсөлдөөнийг дэмжих бодлого баримталах.
- Шуудангийн зах зээлд төрийн өмчит болон хувийн хэвшлийн операторуудын тэгш оролцоог хангах зохицуулалт.
- Давамгайл операторын зах зээлд давамгайл байдлыг хязгаарлах, үнэ тарифын ил тод байдлыг шаарддаг.
- Шуудангийн дижитал шилжилт ба цахим худалдаа
- Шуудангийн байгууллагуудыг e-commerce, fintech зэрэг дижитал үйлчилгээ рүү шилжүүлэх стратеги боловсруулах.
- Цахим төлбөр тооцоо, стандартыг хянах систем, хаягжилтын, дижиталчлал зэргийг нэгдсэн байдлаар хөгжүүлэх.
- Хүргэлтийн дэд бүтэц ба ложистик
- Шуудангийн төв, хүргэлтийн сүлжээ, агуулах, автоматжуулалт зэрэг дэд бүтцийг шинэчилэх.
- Интермодаль логистик, хил дамнасан шуудангийн урсгалыг сайжруулах бодлого хэрэгжүүлэх.
- Олон улсын хамтын ажиллагаа
- Дэлхийн шуудангийн холбоо (Universal Postal Union – UPU)-ны гишүүнчлэлийн хүрээнд стандартыг мөрдөх.
- Хил дамнасан e-commerce, гадаад шуудангийн гаалийн зохицуулалтыг боловсронгуй болгох.

2.4 “Шуудангийн харилцан холболтын журам”-д хийсэн хууль зүйн шинжилгээ болон хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтын талаарх санал:

Нэг. “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг сайжруулах хэрэгцээ, шаардлага, шийдвэрлэх арга замын хүрээнд:

“Шуудангийн харилцан холболтын журам” нь шуудангийн үйлчилгээ үзүүлэгч талуудын харилцан ажиллагааг эрх зүйн хүрээнд зохицуулж, мэдээлэл дамжуулалт, шуудан солилцооны зохистой нөхцөлийг бий болгож буй чухал баримт бичиг юм. Одоо хийгдсэн байгаа судалгаануудад энэ талаар тодорхой санал, дүгнэлтүүдийг тусгасан байгаа ба үүнийг үндэслэн шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн харилцан холболтыг холбогдох

хуулийн хүрээнд үр ашигтай, хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэн чанартай зохион байгуулах боломжтой байна. Журмыг хэрэгжүүлэх явцад иргэний эрх зүйн зохицуулалт, олон улсын шуудангийн стандартуудтай нийцлийг хангаж, эрх зүйн заалтын тодорхой байдлыг сайжруулах шаардлага байсаар байна.

Хоёр. “Шуудангийн харилцан холболтын журам”-ын хууль зүйн техникийн асуудал буюу бусад эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжтой зөрчилдөөн, давхардал, хууль зүйн хийдлийн хүрээнд:

- Шуудангийн харилцан холболт нь хоёр буюу түүнээс дээш шуудангийн операторын (шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч) хооронд шуудан солилцох үйл явц бөгөөд энэ нь зохион байгуулалт, стандарт, техникийн болон аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх ёстой. Журмын 1.4-т харилцан холболтын нөхцөл нь шуудангийн үйлчилгээний стандартын шаардлагыг хангасан горим, шуудангийн илгээмжийг хүргэх хугацааны үзүүлэлтүүд байна гэж заасан нь тавигдах шаардлагын утгыг агуулж байна;
- Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хооронд гэрээнд шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, дамжуулах, хүргэлтэд мөрдөгдөх, стандарт технологийн горим, хүргэлтийн графикт маршрутаар тооцон гаргасан илгээмжийг хүргэх хугацаа, мэдээлэл солилцох, шуудан солилцох нөхцөл, зааглах цэг, аюулгүй байдлыг хариуцах, тарифыг тодорхойдог байна;
- “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг Шуудангийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан шаардлагын хүрээнд үнэлэхэд тус журмын хүрээнд зөрчилдөөн, давхардал илрээгүй болно. Харин Шуудангийн харилцан холболтын журам болон Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл, орлого хуваарилах журам /Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 33 тоот тогтоолын хавсралт/-ын есдүгээр бүлгийн зааг ялгааг нарийвчлах шаардлагатай. тодруулах шаардлагатай байна;
- Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлан гаргасан журмууд нь хууль зүйн техникийн хувьд нэгдсэн бичиглэлийг баримталдаг бөгөөд “Шуудангийн харилцан холболтын журам” энэ шаардлагыг хангаж байна;
- Хоёрдугаар бүлгийн хүрээнд харилцаа холбооны зохицуулах газраас баталсан хэд хэдэн журмыг харах шаардлагатай үүссэн бөгөөд энэ хүрээнд дараах асуудлын анхаарах шаардлага байгааг судалгааны багийн зүгээс зөвлөж байна. Энэ нь журмаар зохицуулж буй харилцааг хуульд оруулах юм. Тодруулбал, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд үндэслэж гарсан цөөнгүй журам байгаа бөгөөд энэхүү судалгаагаар

зөвхөн “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг үнэлсэн. Гэвч цаашид эдгээр журмын агуулгыг Шуудангийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд нийцэж буй эсэхийг тусгайлан шалгах шаардлагатай. Учир нь Манай улсад сүүлийн жилүүдэд хуулиар эрх олгож журам батлах улмаар хуулийн засаглал гэхээс илүүтэй журмын засаглал бүрэлдэн бий болох эрсдэлтэй байгаа талаар судлаачид сануулж байгаа бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайд болон Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс хуулиар эрх олгосон журамд үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай харилцааг журмаар гэхээс илүүтэй хуулиар зохицуулах бодлого баримталж байна. Энэ нь Шуудангийн тухай хуульд мөн хамааралтай юм. Тодруулбал, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.5, 9.1.5 дахь заалтыг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд эдгээр заалтад үндэслэж холбогдох журмын баталсан бөгөөд эдгээр журмаар зохицуулж буй харилцааг үнэлж, цаашид хуульд оруулах талаар шаардлагатай арга хэмжээн авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Гурав. “Шуудангийн харилцан холболтын журам” нь бүхэлдээ болон хэсэгчилсэн байдлаар захиргааны хэм хэмжээний актад бус холбогдох хуульд тусгагдах хүрээнд:

Ямарваа нэг эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтыг хууль эсвэл журамд тусгахын тулд тодорхой шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Энэхүү шаардлагын дагуу дүгнэн үзвэл “Шуудангийн харилцан холболтын журам” нь бүхэлдээ захиргааны хэм хэмжээний актад бус холбогдох хууль буюу Шуудангийн тухай хуульд тусгагдах нь зүйтэй байна.

Дөрөв. “Шуудангийн харилцан холболтын журам”-ын талаарх олон улсын сайн туршлага, эрх зүйн зохицуулалт, түүнээс монгол улсын хууль тогтоомжид нутагшуулах хүрээнд:

- 2019 онд батлагдсан Шуудангийн харилцан холболтын журам нь харилцаа холбоо, тэр тусмаа шуудангийн харилцааны нарийвчилсан хэсэг тул Дэлхийн Шуудан Холбоо (Universal Postal Union – UPU)-ны баталсан Дэлхийн шуудангийн конвенцод нийцэх шаардлагатай;
- Монгол Улсын хувьд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 4, дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 23, улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 66, нийт 93 байгууллага 121 шуудангийн тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа нь Бүгд Найрамдах Казахстан Улсаас ялгагдах тал болж байгаа бөгөөд

тус улсад Казпост ХК-ийг үндэсний шуудангийн оператораар томилсон ба шуудангийн бүхий л үйлчилгээ, зарим тохиолдолд худалдан борлуулах санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна. Харин хувийн компаниудын хувьд зөвхөн хүргэлтийн үйлчилгээгээр хязгаарлагддаг байна;

- Бүгд Найрамдах Солонгос Улсын зохицуулалтыг Монгол Улсын Шуудангийн харилцан холболтын журамтай харьцуулбал либералчлагдсан буюу хуулиар тогтоож зохицуулалгүй ихэвчлэн гэрээнд суурилсан байдлаар харилцан холболтыг хийж байна. Иймд тухайн жишгийг сайтар харгалзан зохицуулах нь зүйтэй.

Жишээлбэл, гэрээний эрх чөлөөг сайтар тусган, гэрээний нөхцөл, гэрээ байгуулахтай холбоотой харилцааг нарийвчлан журамд тусгах шаардлагатай.

- Бүгд Найрамдах Эстони Улсын дээрх зохицуулалт нь Шуудангийн тухай хуульд нарийвчлагдаж зохицуулагдсан ба гэрээний нөхцөл, төлбөр зэргийг оновчтой тусгасан зэргээр сайн жишиг болж байна. Монгол Улсын хувьд дээрхтэй адилаар Шуудангийн харилцан холболтын журмыг хүчингүй болгож Шуудангийн тухай хуульд уг харилцааг зохицуулах боломж байгаа ба мөн нарийвчилсан зохицуулалтыг дээрх жишгийн дагуу тусгаж болохоор байна;
- Шуудангийн тухай хуульд харилцан холболтын талаар ойлголт, шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хооронд байгуулах гэрээнд тусгагдах зүйл, шаардлагын талаар тусгах. Шуудангийн зах зээлийн нөхцөл байдалд уян хатан дасан зохицсон, зах зээлд шударга, үр ашигтай өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх боломжтой зохицуулалтын хүрээ, хэм хэмжээг тодорхой болгох нь нийтлэг зорилт юм.

2.5 Үйлчилгээ эрхлэгчдээс авсан судалгааны тайлан

Олон улсын шуудангийн холбооны баримтлах чиг хандлага, дэлхийн улс орнуудын туршлага, дотоодын нөхцөл байдал, Шуудангийн харилцан холболтын журамд хийсэн хууль зүйн шинжилгээ болон шуудангийн зах зээлийн үр нөлөөний судалгаа шинжилгээний дүгнэлтүүдэд үндэслэж Шуудангийн сүлжээний болон дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс дараах санал асуулгаар уулзалт хийж санал авсан болно. Үүнд:

1. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шуудангийн харилцан холболтын журам танай байгуулагыг шуудангийн харилцан холболт хийхэд ямар нэг дэмжлэг болж чадаж байгаа эсэх;
2. Харилцан холболтын асуудлыг Шуудангийн хуульд бүтэн процессоор нь тусгуулж шуудангийн хуульд нэмэлт өөрчлөлт орох хүртэл хүлээх эсвэл өөрчлөлт орох хүртэл журамдаа холбогдох өөрчлөлт оруулан мөрдөж явах;
3. Журманд сүлжээ бүхий этгээдийг заавал харилцан холболтонд ордог байх гэсэн заалтыг оруулах эсэх;
4. Төлбөрийн бус хугацааны холболтонд орох өөрөөр хэлбэл хамгийн бага хугацаа болон сүлжээний хүртээмж амласан этгээд бусадтай харилцан холболтонд ороход танай компани бэлэн эсэх;
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн ороход бэлэн эсэх;
6. Харилцан холболтын төлбөрийг харилцан тохирох боломжийг нэмэгдүүлэх үүднээс Зах зээлд давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгч Монгол шуудан ХК-ийн зөвхөн БНҮҮ хүлээсэн үйлчилгээнээс бусад үйлчилгээн дээр хатуу тарифын зохицуулалт хийхгүй байх;

Шуудангийн харилцан холболтын зохицуулалтын хүрээнд Монгол шуудан ХК, Монгол инфинити шуудан ХХК, Ашид шуудан ХХК, Юу би каб экспресс ХХК, Амекс Эм Эн Жи ХХК-тай тус тус уулзалт хийсэн.

Монгол шуудан ХК

Монгол шуудан компанийн салбаруудын захирал Баттулгатай хийсэн уулзалтын үед дараах байр суурийг илэрхийлсэн болно. Үүнд:

1. Шуудангийн харилцан холболтын журам хэт ерөнхий сүлжээ бүхий этгээд хоорондоо болон сүлжээгүй этгээд сүлжээтэй этгээдтэй холбогдох асуудлыг нарийн зааглаагүй мөн олон процесс дутуу орхигдсон тул уг журмыг шинэчлэх нь зайлшгүй зүйтэй гэж үзсэн;

2. Харилцан холболтын асуудлыг заавал хуульд тусгах шаардлагагүй журмаар бүрэн зохицуулах боломжтой гэж үзэж байна;
3. Журманд сүлжээ бүхий этгээдийг заавал харилцан холболтонд ордог байх асуудлыг дэмжсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн гэрээнд тусгах боломжтой гэж үзсэн;
4. Төлбөрийн бус хугацааны холболтонд орох өөрөөр хэлбэл хамгийн бага хугацаа болон сүлжээний хүртээмж амласан этгээд бусадтай харилцан холболтонд ороход Монгол шуудан компани бэлэн өнөөг хүртэл өөрийн сүлжээг бусдад нээлттэй байлгаж байгаа бөгөөд гагцхүү сеттлментийн төлбөрөөс хамаарч өнөөг хүртэл харилцан холболт сайн хийгдэхгүй байгаа талаар тайлбарласан;
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн ороход ямар нэг татгалзах зүйлгүй бөгөөд ойрын хугацаанд өөрсдийн смарт бокс ашиглалтанд оруулснаар хяналтын traking систем бий болгож цаашид бий болгосон системээ бусадтай хуваалцахад бэлэн байгаагаа илэрхийлсэн;
6. Зах зээлд давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгчийн хувьд хорооноос хянах боломжтой бүх тарифаа хянуулан батлуулж цаашид хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн болно.

Монгол инфинити шуудан ХХК

Монгол инфинити шуудан компанийн захирал Ф.Ганбаатар дараах саналуудыг өгсөн болно.

Үүнд:

1. Шуудангийн харилцан холболтын журмыг шинэчлэх шаардлагатай байна. Журам хэт цомхон олон асуудал зохицуулалтгүй үлдэж байна;
2. Харилцан холболтын асуудлыг заавал хуульд тусгах шаардлагагүй хэдий ч хууль гартал журмаа шинэчлээд мөрдөж явах бүрэн боломжтой бөгөөд журам шинэчлэхэд оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн;
3. Журманд сүлжээ бүхий этгээдийг заавал харилцан холболтонд ордог байх асуудлыг бүрэн дэмжсэн болно;
4. Төлбөрийн бус хугацааны холболтонд орох өөрөөр хэлбэл хамгийн бага хугацаа болон сүлжээний хүртээмж амласан этгээд бусадтай харилцан холболтонд ороход бэлэн бөгөөд төлбөрийн хэмжээг хугацаанаас хамааруулан тогтоодог болох асуудлыг журманд тусгах хүсэлтээ илэрхийлсэн;
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн орохыг дэмжиж байна;

6. Монгол шуудан ХК-ийн зөвхөн БНҮҮ хүлээсэн үйлчилгээнээс бусад үйлчилгээн дээр хатуу тарифын зохицуулалт хийхгүй байх асуудлыг Зохицуулах хороо өөрсдийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй байх.

Ашид шуудан ХХК

“Ашид шуудан” компанийн захирал Түшиг асуулгатай холбоотой дараах саналуудыг илэрхийлсэн. Үүнд:

1. Шуудангийн харилцан холболтын журмыг шинэчлэх эсэх талаар сайн мэдэхгүй байна. Одоогоор тухайн журамтай холбоотой хүндрэл тулгараагүй байна. Харилцаа холбооны салбарт ажиллаж байсан хүний хувьд хэлэхэд шуудангийн гэхээсээ илүү харилцаа холбооны журам шиг санагддаг;
2. Харилцан холболтын асуудлыг заавал хуульд тусгах шаардлагатай эсэх талаар сайн хэлж мэдэхгүй байна;
3. Журманд сүлжээ бүхий этгээдийг заавал харилцан холболтонд ордог байх асуудлыг дэмжиж байна. Гэхдээ бид өөрийн сүлжээг байгуулж тодорхой чиг үүрэг бүхий салбарт ашиглуулахаар гэрээ хэлцэл хийж байна;
4. Төлбөрийн бус хугацааны холболтонд орох өөрөөр хэлбэл хамгийн бага хугацаа болон сүлжээний хүртээмж амласан этгээд бусадтай харилцан холболтонд орохыг дэмжиж байна;
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн орохыг дэмжиж байна;
6. Монгол шуудан ХК-ийн зөвхөн БНҮҮ хүлээсэн үйлчилгээнээс бусад үйлчилгээн дээр хатуу тарифын зохицуулалт хийхгүй байх асуудлыг сайн мэдэхгүй байна. Зохицуулах байгууллага өөрсдийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй байх.

Юуби каб экспресс ХХК

Юуби каб экспресс компанийн захирал Ө.Батзоригтой хийсэн уулзалтын тэмдэглэлийн дагуу товч утгыг илэрхийлбэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Шуудангийн харилцан холболтын журам шаардлага хангахгүй байна. Зайлшгүй өөрчлөх шаардлагатай;
2. Харилцан холболтын асуудлыг заавал хуульд тусгах шаардлагагүй. Хуулийн өөрчлөлт ойрын хугацаанд шийдэгдэх эсэх тодорхойгүй байна;
3. Журманд сүлжээ бүхий этгээдийг заавал харилцан холболтонд ордог байх асуудлыг дэмжиж байна. Манай компани жилд 1.3–2 сая хэрэглэгчдэд үйлчилдэг, үндсэн сүлжээний дайтай гэж үзэж байна. Харилцан холболт аль болох нээлттэй баймаар байна. Тусгай зөвшөөрлийн хүрээнд бид сүлжээ байгуулах эрхгүй байна;
4. Төлбөрийн бус хугацааны холболтонд орох өөрөөр хэлбэл хамгийн бага хугацаа болон сүлжээний хүртээмж амласан этгээд бусадтай харилцан холболтонд орохыг дэмжиж байна. Шуудангийн хүргэлтийн хугацаанаас хамаарч үнийн тарифт өөрчлөлт оруулах шаардлагатай;
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн орохыг дэмжиж байна. Ю.Би Кап аппликэйшнд шинэчлэл хийж байгаа бөгөөд одоогоор 1.5 сая хэрэглэгчтэй. Хэрэглэгчдийн гол хэрэгцээ нь илгээмжийн байршлыг мэдэх (tracking) бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх шинэ систем нэвтрүүлэхээр ажиллаж байна. Монгол шуудан болон бусад логистикийн компаниуд нэг ижил tracking системтэй боловч хэрэглэгчдэд бүрэн хүрч чадахгүй байна. Харин Ю.Би Капын системийг нээлттэй болгосноор олон компанийн холболт хийх боломжтой. MN Post болон бусад 4 компанитай хамтран ажиллаж, илгээмжийн статус шалгах системийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь хүргэлтийн хурдыг нэмэгдүүлж байна;
6. Монгол шуудан ХК-ийн зөвхөн БНҮҮ хүлээсэн үйлчилгээнээс бусад үйлчилгээн дээр хатуу тарифын зохицуулалт хийхгүй асуудлыг дэмжиж байгаа хэдий ч SIDE EFFECT буюу дагалдаж гарах бусад эрсдэлийг сайтар тооцох нь зүйтэй байх.

Амекс Эм Эн Жи ХХК

“Амекс Эм Эн Жи” компанийн захирал Ганчимэгтэй уулзалт хийсэн. Үүнд:

1. Шуудангийн харилцан холболтын журмыг шинэчлэх эсэх талаар сайн мэдэхгүй байна. Яг тухайн журамтай холбоотой хүндрэл тулгараагүй байна;
2. Харилцан холболтын асуудлыг заавал хуульд тусгах шаардлагатай эсэх талаар сайн хэлж мэдэхгүй байна;

3. Журманд сүлжээ бүхий этгээдийг заавал харилцан холболтонд ордог байх асуудлыг дэмжиж байна. Манай компани орон нутагт хүргэлт хийлгэх шаардлагатай ачааг Монгол шуудан ХК-аар хүргүүлдэг. Гэхдээ хүлээн авагч төлбөрөө төлдөг байдлаар хүргүүлдэг тул тусгайлан гэрээ байгуулдаггүй Монгол шуудан ХК-ын илгээлтийн тарифаар хүргүүлдэг;
4. Төлбөрийн бус хугацааны холболтонд орох талаар дүгнэлт хэлэх боломжгүй байна. Илгээлтийн тариф аль болох хямд байвал хэрэглэгчид хэрэгтэй байна;
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн орохыг дэмжиж байна;
6. Монгол шуудан ХК-ийн илгээлтийн тарифыг хямд үнэтэй байлгахыг дэмжиж байна. Мөн Зохицуулах байгууллага зохицуулалтын үйлчилгээний хөлсийг нэмэхгүй тогтвортой байлгахыг хүсч байна.

2.6 Шуудангийн харилцан холболт хийхэд баримтлах зарчмыг шинэчлэх талаарх санал:

Шуудангийн харилцан холболт хийхэд дараах зарчмуудыг ШИНЭЧЛЭХ нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Талууд харилцан холболтын тарифыг Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу үйлчлэгчийн эрх бүхий этгээдээр батлуулан мөрдөнө. Харилцан холболтын гэрээний үнийг эрх бүхий этгээд баталж хянахдаа хүргэлтийн зах зээл дэх хамгийн доод үнийг баталж өгөх шаардлагатай. Ингэснээр хэн нэг сүлжээ эзэмшигч давуу эрх эдлэх, өөрийн баталсан үнийг тулган шаардахаас сэргийлнэ. Гэрээний үнийг дагаад хүргэлтийн бүсийн зааг тодорхойлогдох учир алс зайн хүргэлтийг санаатай авахгүй байх, хэрэглэгчийг ялгаварлан гадуурхагдах нөхцөлийг хааж өгнө.
- 3.Талууд харилцан холболтод орохдоо хүргэлтийн хугацааг Шуудангийн тухай хуулийн 9.1.6 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий этгээдээр батлуулан мөрдөнө.
- 4.Шуудангийн сүлжээ байгуулах болон шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлагад сүлжээ ашиглалтын чанар, технологи ажиллагааны шаардлагуудыг нэмэлтээр оруулж өгнө.
- 5.Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон шуудангийн илгээмж хүргэх хугацааг мөрдөж ажиллана.
6. Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотуудын хооронд 5 хоног бусад газар (улс хооронд, баг) 12 хоногийн дотор хүргэх.

7. Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацаа нь үйлчлэгч хоорондын гэрээнд зааснаар тодорхойлогдох бөгөөд энэ нөхцөл шаардлагын 3.1.1-т заасан хугацаанаас богино байх Үүнд:

- Эрх бүхий байгууллагаас тухайн хугацааг зах зээлийн хамгийн бага хугацаагаар шинэчлэн батлаж өгөх шаардлагатай. Хүргэлтийн зах зээлийн хөгжих түлхүүр нь хүргэлтийн хамгийн богино хугацаа. Өнөөгийн нөхцөлд хот доторхи хүргэлт 6 цагийн дотор хүргэгдэж байна. Хугацаанаас хамаарсан үнийн бодлогыг цаашид хэрэгжүүлэх.
- Хүргэлтийн хугацаатай холбоотой харилцан холболтонд орохдоо бүртгэл хяналтын системийг интеграцчилах. Үүнийг анхны нөхцөл шаардлага болох шуудангийн сүлжээ болон үйлчилгээ эрхлэх нөхцөл шаардлагад бүртгэл хяналтын систем API гаргах гэж тусгах.
- Цаашлаад бүртгэл хяналтын системийн холболтоор хүргэлтийн хугацааг тооцох, үүнтэй уялдан гэрээний үнийн дүнг амжилттай хүргэлтээс хамаарсан KPI –жуулах боломжийг бүрдүүлж өгнө.

2.7 Дүгнэлт

1. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРАМ нь бүхэлдээ Харилцаа холбооны сүлжээ бүхий этгээд хооронд харилцан холболт хийх зарчимд тулгуурлан боловсруулагдсан бөгөөд өөр төрлийн зохицуулалттай шуудангийн салбарт шууд авч ашиглахад түвэгтэй байдалтай байна.
2. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРАМ-ыг сүлжээ бүхий этгээдүүдийн харилцан холболт болон сүлжээгүй этгээдүүд СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ гэж ангилж зохицуулах шаардлага үүссэн байна.
3. Санал асуулгад оролцсон этгээдүүд бүгд журмыг шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.
4. Шуудангийн харилцан холболтын асуудал Шуудангийн сүлжээ бүхий этгээд хооронд гэхээс илүү өөрийн сүлжээгүй этгээд, сүлжээ бүхий этгээдийн сүлжээнд холбогдож улс хоорондын болон дотоодын шуудангийн үйлчилгээг үзүүлэхэд гардаг алдагдлыг бууруулах, үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, салбарын эдийн засгийн өсөлтийг дэмжих үндсэн суурь зарчмыг хангах боломжгүй байдалтай байна.

5. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ.
- 2.2. *Харилцан холболт хийх үйлчилгээний тариф нь бизнесийн аливаа алдагдлыг нөхөхгүй, өртөгт үндэслэсэн, талуудын эрх ашигт нийцсэн байна* гэдэг нь тунхагийн чанартай хэрэгжилтэнд хяналт тавих төвөгтэй байдал үүсгэж байна.
- 2.4. *Харилцан холболтын явцад шинэ техник, технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой нэмэлт хөрөнгө оруулалт, зардлыг талууд харилцан тохиролцоно* гэсэн заалт хэт ерөнхий тул бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээд харилцан холболтонд нэгдэн орох боломж тодорхой бус байна.
6. Харилцан холболтын зарчмыг дижиталчлах илүү дундын TRAKING систем руу хандуулах шаардлагатай болсон байна гэж үзэж байна.
7. Харилцан холболтонд хүргэлтийн бүсчлэл болон хугацааны асуудлыг илүү чухалчлах тусгах шаардлагатай байна.
8. Илгээмж хүргэлтийн асуудалд зах зээлд давамгайл байдалтай Монгол шуудан ХК-ийн үнэ тарифыг хянаж батлах үйлчилгээний хүрээг эргэж харах шаардлагатай гэж үзэж байна.
9. Шуудангийн харилцан холболтыг нэмэгдүүлэх, бүсчилсэн тогтолцоо нэвтрүүлэх стратеги зорилтын хүрээнд бүсчилсэн тогтолцоо болон харилцан холболт гэсэн ойлголтыг илүү тодорхой болгож тодорхой заалтуудыг журамлах боломжтой гэж үзэж байна.
10. Тусгай зөвшөөрлийн хувьд Шуудангийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлагыг харилцан холболтын журмаар тодотгох боломжтой. 3.2. *Талууд харилцан холболтын тарифыг Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу үйлчлэгчийн эрх бүхий этгээдээр батлуулан мөрдөнө* гэсэн заалтад хяналт тавих боломжгүй гэж үзэж байна. Ер нь харилцан холболт тарифын гэхээс илүү зохцуулалтын агуулгатай байна.
11. Цаашид харилцан холболтыг холбогдох төлбөрийн хэмжээ (termination rate) бус хүргэлтийн хугацаагаар хэмжиж харилцан холболтын гэрээ байгуулах боломжийг зохицуулалтаар дэмжин ажиллах шаардлага үүсч байна.

2.8 Зохицуулах хороонд өгөх зөвлөмж

1. Харилцан холболтын асуудлыг Шуудангийн тухай хуульд тусгаж шийдвэрлүүлэх хүртэл холбогдох журмын асуудлыг шинэчилж мөрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
2. Журам боловсруулахад үйлчилгээ эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан санал авч төслийг боловсруулах нь зүйтэй.
3. Журмын төсөлд шуудангийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч болон дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэгч нарын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох боломжтой.
4. Цаашид сүлжээ бүхий үйлчилгээ эрхлэгчдийн эрх үүргийг журамд илүү тодорхой тусгах шаардлагатай.
5. Бодит болон виртуал сүлжээ бүхий хуулийн этгээдийн харилцан холболтонд орох процессийг илүү тодорхой болгох шаардлагатай байна.
6. Нэгдсэн TRAKING бий болгох, шуудангийн солилцоо, ялган боловсруулах дамжлагыг аль болох хурдасгах процессыг журамд тусгах боломжтой.
7. Өөрийн сүлжээгүй боловч цахим худалдаг голчлон хийж буй компаниудын тусгай зөвшөөрлийн хүрээг нэмэгдүүлэх эсрэгээрээ сүлжээний тусгай зөвшөөрөлтэй боловч хамрах хүрээг тэлэхгүй байгаа үйлчилгээ эрхлэгчдэд тодорхой үүрэг хүлээлгэх боломжтой.
8. Шуудангийн үйлчилгээний зах зээлд давамгай байдалтай Монгол шуудан ХК-ийн үнэ тарифыг хянаж батлах үйлчилгээний хүрээг эргэж харах ингэснээр харилцан холболт хийх сүлжээнд холбогдох тарифын асуудлыг шийдвэрлэх боломжтой.

2.9 Ашигласан материалууд:

Universal Postal Union (UPU) Documents

- UPU Acts (e.g., the *Universal Postal Convention and Regulations*):

These define the rules and technical standards for the international postal network.

UPU Technical Standards:

Examples include standards for address formatting (S42), mail exchange formats, postal data transfer, and electronic exchange protocols.

UPU Postal Strategy Reports:

These strategic documents often discuss the modernization and digitalization of postal interconnection, regional cooperation, and integration with ICTs.

Regional and National Case Studies

- European Union Postal Directives:

The EU has binding directives promoting liberalization and interconnection of national postal operators (e.g., *Postal Directive 97/67/EC* and updates). Case Studies:

- *Korea Post* — well-known for advanced postal ICT integration.
- *Thailand Post* — modernization and regional ASEAN cooperation.
- *Malaysia Pos* — public-private interconnection models.

Academic Papers and Books

1. Crew, M. A. & Kleindorfer, P. R. — *Liberalization of the Postal and Delivery Sector*. Discusses the economic and policy aspects of interconnection.
2. UPU & ITU Joint Reports — *Digital Economy and Postal Services*. Focus on how postal interconnection links with e-commerce and digitalization.
3. OECD Postal Policy Papers — Analysis of interconnection, competition, and universal service.

Related Standards & Forums

- CEN (European Committee for Standardization) TC331: Develops European postal standards.
- ITU-T: For postal ICT interconnection (e.g., EDI, secure digital channels).
- WCO (World Customs Organization): Cooperation protocols for cross-border postal and customs interconnection.